

## 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛД ИРГЭД, БАЙГУУЛЛАГААС ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГАД ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН МЭДЭЭ

### **Нэг. Иргэд, байгууллагаас цагдаагийн байгууллага, албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар**

Төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн албан тушаалтанд 2017 оны эхний хагас жилд иргэд, байгууллагаас 5175 санал, өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 278 нэгж буюу 5.7 хувиар өсчээ.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 31 буюу 0.6 хувь нь санал, 5068 буюу 97.9 хувь нь өргөдөл, 76 буюу 1.5 хувь нь гомдол байна.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдол



Санал, өргөдөл, гомдлыг утгаар нь авч үзвэл: 645 буюу 12.5 хувь нь ажилд орох, суралцахыг хүссэн, 204 буюу 3.9 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 751 буюу 14.5 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 1564 буюу 30.2 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 217 буюу 4.2 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 1794 буюу 34.7 хувь нь бусад өргөдөл гомдол байна.

Нийт хүлээн авсан санал, өргөдөл, гомдлын 5097 буюу 98.5 хувийг шийдвэрлэж, 78 буюу 1.5 хувь нь ажиллагаанд байна.




**Хоёр. Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн талаар**

2017 оны эхний хагас жилд Цагдаагийн ерөнхий газрын удирдлагуудад иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас 443 өргөдөл, гомдол ирүүлснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33 нэгж буюу 8.0 хувиар өсчээ.

Нийт хүлээн авсан өргөдөл, гомдлын 3 буюу 0.7 хувь нь санал, 26 буюу 5.9 хувь нь гомдол, 414 буюу 93.4 хувь нь өргөдөл байна.




Иргэд, байгууллагаас цагдаагийн албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл, гомдлыг үтгээр нь авч үзвэл: 31 буюу 7.0 хувь нь ажилд орох суралцахыг хүссэн, 76 буюу 17.2 хувь нь ажилд дахин орохыг хүссэн, 61 буюу 13.8 хувь нь ажил өөрчлөх, шилжихийг хүссэн, 8 буюу 1.8 хувь нь захиргааны чөлөө хүссэн, 51 буюу 11.5 хувь нь тэтгэвэр, тэтгэмж, орон сууц хүссэн, 216 буюу 48.7 хувь нь бусад өргөдөл, гомдол байна.



**Гурав. Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 11-11 төвд ирсэн өргөдөл, гомдол, шүүмжлэл, санал хүсэлтийн талаар**

2017 оны эхний хагас жилд иргэдээс Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын “11-11” төвд цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 216 санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдөл ирүүлсний 117 буюу 54.2 хувь нь санал хүсэлт, 70 буюу 32.4 хувь нь гомдол, 25 буюу 11.6 хувь нь талархал, 2 буюу 0.9 хувь нь шүүмжлэл, 2 буюу 0.9 хувь нь өргөдөл байна.



Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, гомдол, талархал, шүүмжлэл, өргөдлийн 127 буюу 58.8 хувийг шийдвэрлэж, 89 буюу 41.2 хувь нь ажиллагаанд байна.

Иргэдэд хариу хүргүүлсэн байдлыг чанараар нь авч үзвэл 49 буюу 38.6 хувийг 5 хоногийн дотор, 78 буюу 61.4 хувийг 5-аас дээш хоногт шийдвэрлэжээ.

**Дөрөв. Иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар**

2017 оны эхний хагас жилд иргэд, байгууллагаас цагдаагийн алба хаагчтай холбоотой 867 өргөдөл, гомдол хүлээн авч шалгасныг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 57 нэгж буюу 7.0 хувиар өсч, 951 алба хаагч холбогдсоны 798 буюу 83.9 хувь нь офицер, 150 буюу 15.8 хувь нь ахлагч, 3 буюу 0.3 хувь нь энгийн ажилтан байна. Нийт өргөдөл гомдлын 796 буюу 91.8 хувийг барагдуулж, 71 буюу 8.2 хувь нь ажиллагаанд байна.

